


ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/09-2023/01/13

ТОП 20 индекс



МХБ-ын Топ 20 индекс өнгөрсөн долоон хоногт 37,061 нэгжид хүрч өнгөрсөн 7 хоногоос 0.17%-иар нэмэгдэж харьцангуй тогтвортой үзүүлэлттэй байв. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.86 их наяд ₮ хүрээд байна.

Энэ оны эхний 7 хоногт Монголын хөрөнгийн биржээр 86 компанийн 17.5 тэрбум ₮-ийн 135.7 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан ба арилжааны дүн өмнөх долоон хоногоос 8.3 дахин өссөн байна.

Үүнээс 484.4 сая ₮-ийн ХБҮЦ, 43.6 сая ₮-ийн компанийн бонд, 1.26 тэрбум ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 14 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан эдгээр хувьцаанууд нь өнгөрсөн 7 хоногийн нийт хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны 22.1%-ийг эзэлж байна. 2022 оны сүүлийн долоон хоногт IPO хийсэн “Монголын хөрөнгийн бирж” ХК арилжааны дүнгээр тэргүүлсэн бол АПУ ХК, Голомт Банк ХК нь мөн өнгөрсөн долоон хоногийн топ идэвхитэй хувьцаануудын тоонд орсон байна.

Өнгөрсөн долоон хоногт “Монголын хөрөнгийн бирж” ХК арилжааны дүнгээр тэргүүлсэн бол ханшийн өсөлтийн хувь хэмжээгээр ч мөн адил тэргүүлсэн байна. Анх 100₮-өөр нэгж хувьцаагаа олон нийтэд санал болгосон бол өнөөгийн байдлаар 162.12₮ хүрээд байна.

2023 оны эхний хоёр долоон хоногийн арилжаагаар Крипто үндэстэн ХК дараалан ханшийн уналтаар тэргүүлээд байна. Мөн Монгол савхи ХК, Увч чацаргана ХК-иуд харгалзан 11.8 сая ₮, 22.7 сая ₮-өөр арилжаалагдаж 15%, 12.93%-иар унасан байна.

ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Монголын Хөрөнгийн Бирж	1,907,508,444
Ард Даатгал	621,956,816
Голомт Банк	205,487,475
АПУ	193,657,769
Эрдэнэ ресурс девелопмент	166,575,008

ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
МХБ	1,907,508,444	62.12%
Хорин хоёрдугаар бааз	4,176,260	32.08%
Хөх Ган	558,825	27.92%
Дархан нэхий	4,167,490	15.86%
Блюскай секьюритиз	53,820	15.00%

ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Крипто Үндэстэн	2,452,830	-33.33%
Эрдэнэс сольюшинс	18,225	-25.77%
Монгол савхи	11,811,827	-15.00%
Увч чацаргана	22,692,467	-12.93%
Адуун Чулуун	24,000	-11.22%

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



+976 75100575



info@rhinosinvest.mn



www.rhinosinvest.mn

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/09-2023/01/13

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Экспортод гаргах нүүрсний туршилтын арилжаа амжилттай явагдаж, арилжаанд оролцогч худалдан авагчдыг бүртгэж эхэллээ.

- 2023/01/12-ны өдөр нүүрс худалдах болон худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийг оролцуулсан туршилтын арилжаагаар худалдах талаас 2 багц буюу нийт 12,800 тонн нүүрсийг худалдах санал ирүүлсэн бөгөөд 1 удаагийн хэлцлээр 2 багц нүүрсийг амжилттай арилжлаа. Дуудлага арилжаагаар дуудах үнэ 12.2%-иар өссөн байна.



“МОН БИЙФ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болно

- “Мон Бийф” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022/12/23-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлалаа.
- Хугацаа: 2023/02/06-ны өдрийн 14:00 цагт
- Байршил: Цахим флатформ /зайнаас/
- Бүртгэлийн өдөр: 2023/01/13-ны өдөр
- Хурлаар хэлэлцэх асуудлууд: “Мон Бийф” хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

